



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын 2-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/200/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: М.Энхжаргал Утас: 99812792 Цахим хаяг: Enkhjargalm@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг . Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мян. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>		
Эргэлтийн хөрөнгийн дүн	144,839.7	323,768.1
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,861,305.1	1,846,689.8
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,006,144.8</b>	<b>2,170,457.9</b>
Нийт өр төлбөрийн дүн		13,776.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,006,144.8	2,156,681.1
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,006,144.8</b>	<b>2,170,457.9</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,303,543.3	2,799,525.3
Үйл ажиллагааны зардлын дүн	2,288,264.5	2,639,812.0
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>15,278.7</b>	<b>159,713.3</b>
Үйл ажиллагааны бус үр дүн		9,177.1
<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>15,278.7</b>	<b>150,536.2</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,006,144.8	2,006,144.8
Тайлант оны үр дүн		150,536.2
<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>2,006,144.8</b>	<b>2,156,681.0</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,238,246.7	2,660,100.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,161,040.7	2,504,620.6
<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>77,206.1</b>	<b>155,480.2</b>
<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	-	
<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>77,206.1</b>	<b>155,480.2</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>77,206.1</b>	<b>155,480.2</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	77,206.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,206.1	232,686.3
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>		
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>2,161,040.7</b>	<b>2,503,731.4</b>
Урсгал зардал	2,161,040.7	2,503,731.4
Хөрөнгийн зардал		
<b>Эргэж төлөгдөх зээл</b>		
<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>2,238,246.7</b>	<b>2,659,211.6</b>
Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,161,040.7	2,648,498.3
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос		
Туслах үйл ажиллагааны орлогоос		10,713.3
Урьд оны үлдэгдлээс санхүүжих /бусад/		
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,206.06	232,686.2

## Хоёр . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 61,214.81 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 47,756.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Сурах бичиг данснаас хасахдаа үндсэн хөрөнгийн гарз дансанд тусгаагүй ном хэвлэл худалдан авах зардалд бүртгэснийг,
- Сургуулийн асран хамгаалагчид, төгсөгчдийн хандиваар өгсөн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, ОНХС-аар хийгдсэн сургуулийн дотуур байрны засварын ажлыг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг,

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудал нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 13,458.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Зардлын данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэг болон боловсролын жуух бичгээр шагнагдсан хүмүүст сайдын тушаалаар батлагдсан журам баримтлан мөнгөн шагнал олгосон, ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд үндэслээгүй, амжилтын түвшнийг харгалзан үзэлгүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Төрийн албан хаагчид шагнал олгох журмын 1.7-д “Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35 / А/10 / 9 дүгээр "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 болон 10 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдуулан олгохгүй байх, ур чадварын нэмэгдлийг тушаалд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж холбогдох түвшинд харгалзах хувиар олгох.

#### 2. **Газартай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Газрын гэрчилгээг шинэчлээгүйтэй холбоотой газрын кадастрын зураг байхгүй байна. Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Газрын асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Гурав. Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8					13	14
Булган сумын 2-р сургууль	Акталсан хөрөнгийн гарзыг санхүүгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн байна.	1	9,177.01			1	9,177.01	1	9,177.01				
Булган сумын 2-р сургууль	Сургуулийн асран хамгаалагчид, төгсөгчдийн хандиваар өгсөн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, ОНХС-аар хийгдсэн сургуулийн дотуур байрны засварын ажлыг санхүүгийн тайланд тусгаагүй байсан	1	38,579.00	1	38,579.00		38,579.00	1	38,579.00				
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>47,756.01</b>	<b>1</b>	<b>38,579.00</b>	<b>1.00</b>	<b>47,756.01</b>	<b>2</b>	<b>47,756.01</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Булган сумын 2-р сургууль	Багш ажилчдад олгох урчадварын нэмэгдлийг холбогдох журам зааврын дагуу бодитой дүгнэн олгох	1	13,458.80					1	13,458.80		
Булган сумын 2-р сургууль	Санхүүгийн тайланд бүртгэлтэй газар кадастрын хэмжээнээс зөрүүтэй	1						1			
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>13,458.80</b>					<b>2</b>	<b>13,458.80</b>		

**ДӨРӨВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
<b>НИЙТ</b>			1	-	-	1	-	-	-